213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	4,615.20
213405	Орон нутгийн төсвийн срөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.06	0.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	0.00	60,000.00
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	0.00	60,000.00
223001	Бусад хөрөнгө	0.00	60,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	230,659.01	133,696.03
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	230,659.01	133,696.03
131101	Төрийн болон орон нутгийн өмчигт бус этгээдээс авсан хандив, тусламж	18,091.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	208,125.44	110,496.03
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,442.57	23,200.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	4,615.20
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,615.20	0.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Баянхангай сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьялах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьялах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьялах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьялагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар наадмын талбайн засвар 50,000.0 мянган төгрөг, явган хүний зам 20,000.0 мянган төгрөг, сумын төвийн гэрэлтүүлэг 20,000.0 мянган төгрөг, аймгаас эрх шилжүүлж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хөрөнгө оруулалтаар спорт чийрэгжүүлэлт биеийн тамирын талбай 60,000.0 мянган төгрөг, 2 автомашиныг 60,000.0 мянган төгрөг, Найрамдал багт гүний худаг 20,000.0 мянган төгрөг, Нарлаг хороололд дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлэхээр 98,000.0 мянган төгрөгийн ажлууд тус тус хийгдсэн байна.

БНСУ-н ЗГ-аас хэрэгжүүлсэн цөлжилт, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах зорилгоор 5 жилийн хугацаатай 100 га газарт ойжуулалт, хүлэмж, хүнсний ногоо тариалж 30 хүнийг ажлын байртай болгох ажлыг эхлүүлсэн байна. Нэг жилд 640,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байна. Мөн Баянхангай, Угтаалцайдам, Цээл, Заамар чиглэлийн 121,7 км авто замын ажил хийгдэж эхэлсэн байна.

Төв аймгийн Засаг даргын 2023 оны А/45 дугаар захирамжаар сумдын 2022 оны үйл ажиллагааг дүгнэхэд тус сум нь 84,9 хувьтай, “Ногоон хөгжил-Баялаг бүтээгчид”-ийг дэмжих урианы жилийн хэрэгжилт 82,9 хувьтай тус тус дүгнэгдсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Баянхангай сумын Засаг дарга нь үйл ажиллагаандaa Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанцад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналтын төлөвлөгөөг 2022 онд нийт 9 ажил үүрэг гүйцэтгэхээр төлөвлөн батлуулсан байна. Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг нь удирдамж батлуулан байгууллагуудын санхүүгийн анхан шатны баримтын хөтлөлт, бараа материалын зарцуулалт, хөрөнгө оруулалтын ажлын явцын гүйцэтгэл, шилэн дансны хөтлөлтөд хяналт хийж, зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайланын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайланын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын нэгтгэсэн тайландаа мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,554,707.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,167,645.9 мянган төгрөгөөр буюу 58,2 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөгөөр/
Мөнгөн хөрөнгө	94,506.18	61,848.57	-32,657.61
Авлага	334,394.66	332,690.92	-1,703.74
Бараа материал	216,203.94	88,588.56	-127,615.38
Үндсэн хөрөнгө	3,077,249.08	1,071,579.89	-2,005,669.19
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,722,353.86</b>	<b>1,554,707.94</b>	<b>-2,167,645.92</b>
Өр төлбөр	1,881.13	9,581.12	7,699.99
Засгийн газрын хүтээ оролцоо /Эздийн өмч/	3,720,472.74	1,545,126.83	-2,175,345.91
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө / өмчийн дүн</b>	<b>3,722,353.86</b>	<b>1,554,707.94</b>	<b>-2,167,645.92</b>

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 61,848.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 32,657.6 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын дансны эцсийн үлдэгдэл 25,373.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 34,753.3 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн төвийн данс эцсийн үлдэгдэлгүй болж өмнөх оноос 21,510.5 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 332,690.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,703.7 мянган төгрөгөөр буурсан нь сум хөгжүүлэх сангийн авлага 91,389.2 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн төвийн авлага 78,076.5 мянган төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 88,588.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 127,615.3 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд харьяа байгууллагууддаа санхүүгийн тайлангаа нэгтгэдэг болсноор Эрүүл мэндийн төвийн 8,740.8 мянган төгрөг, ЕБС-ийн 49,761.8 мянган төгрөг, Цэцэрлэгийн 26,444.5 мянган төгрөг, Соёлын төвийн 8,210.2 мянган төгрөг, нийт 93,157.3 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,071,579.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,005,669.1 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн

ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 2,800,018.96 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 1,545,126.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,175,345.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн, Соёлын төвийн байгууллагуудын авлага, засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 1,952,828.7 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 61,848.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 32,657.6 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>94,506.18</b>	<b>61,848.57</b>	<b>-32,657.61</b>
<b>Төгрөг</b>	<b>94,506.18</b>	<b>61,848.57</b>	<b>-32,657.61</b>
Төрийн сангийн харилцах	83,346.48	56,827.03	-26,519.45
Арилжааны банк дахь харилцах	6,544.50	5,021.54	-1,522.96
Нэмэлт санхүүжилтийн харилцах	4,615.20	0.00	-4,615.20
<b>Дүн</b>	<b>94,506.18</b>	<b>61,848.57</b>	<b>-32,657.61</b>

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгээсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 56,827.0 мянган төгрөгийн 44,6 хувь буюу 25,373.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 45,7 хувь буюу 25,987.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 9,6 хувь буюу 5,466.3 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл тус тус байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 32,657.6 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн ерөнхий орлогын дансны эцсийн үлдэгдэл 25,373.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 34,753.3 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн төвийн данс эцсийн үлдэгдэлгүй болж өмнөх оноос 21,510.5 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 332,690.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,703.7 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 3 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	150.00	150.00	0.00
Байгууллагаас авах авлага	82,259.72	71,315.48	-10,944.23
Хувь хүмүүсээс авах авлага	251,984.95	261,225.44	9,240.49
<b>Дүн</b>	<b>334,394.66</b>	<b>332,690.92</b>	<b>-1,703.74</b>

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгээсэн тайлан

Авлагын жилийн эцсийн үлдэгдэл 332,690.9 мянган төгрөгийн 77,0 хувийг хувь буюу 256,225.4 мянган төгрөгийг хүмүүсээс авах авлага эзэлж байна. Энэ нь хоршоо хөгжүүлэх сангийн авлага байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 88,588.5 мянган төгрөг болж, өмнөх оноос

127,615.3 мянган төгрөгөөр буурсан байна.

#### **Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл**

/мянган төгрөгөөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>72,306.50</b>	<b>38,898.51</b>	<b>-33,407.99</b>
Эм боох материал	72,306.50	38,898.51	-33,407.99
<b>Хангамжийн материал</b>	<b>143,897.44</b>	<b>49,690.05</b>	<b>-94,207.39</b>
Бичиг хэргийн материал	6,166.40	4,912.01	-1,254.39
Аж ахуйн материал	106,082.72	32,345.34	-73,737.39
Сэлбэг хэрэгсэл	-	53.00	53.00
Түлш, шатах тослох материал	1,278.45	-	-1,278.45
Хүнсний материал	12,799.00	-	-12,799.00
Бусад хангамжийн материал	17,570.87	12,379.70	-5,191.17
<b>Нөөцийн бараа</b>			0.00
<b>Дүн</b>	<b>216,203.94</b>	<b>88,588.56</b>	<b>-127,615.38</b>

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 88,588.5 мянган төгрөгийн 39,020.2 мянган төгрөг буюу 44,0 хувийг эмийн эргэлтийн сан, 45,448.9 мянган төгрөг буюу 51,3 хувийг ЗДТГ, 4,119.3 мянган төгрөг буюу 4,6 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын оны эцсийн үлдэгдэл 127,615.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС-ийн 56,297.9 мянган төгрөг, Цэцэрлэгийн 35,637.9 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 61,195.1 мянган төгрөг, Соёлын төвийн 8,270.2 мянган төгрөг, нийт 161,401.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг улсын төсвийн байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайланда хийсэн аудитаар:

- Тайлант хугацаанд 1,226.4 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүй зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

#### **3.4.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,071,579.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,005,669.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн 1,886,865.7 мянган төгрөгийн үлдэгдлийн 99,2 хувь буюу 1,872,487.1 мянган төгрөгийг сумын ЗДТГ, үлдэх хувийг эмийн эргэлтийн сан, ИТХ, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,801,581.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 313,394.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд ЕБС-ийн 1,892,900.6 мянган төгрөгийн, Цэцэрлэгийн 248,998.1 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 434,456.6 мянган төгрөгийн, Соёлын төвийн 223,663.2 мянган төгрөгийн, нийт 2,800,018.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

### **Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл**

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>4,296,092.32</b>	<b>1,835,762.87</b>	<b>-2,460,329.45</b>
Барилга, байгууламж, орон сууц	3,189,571.94	961,234.54	-2,228,337.40
Авто тээврийн хэрэгсэл	228,969.58	401,611.39	172,641.82
Машин тоног төхөөрөмж	423,712.83	167,305.27	-256,407.57
Тавилга, аж ахуйн эд хогшил	165,269.26	38,793.26	-126,476.01
Бусад үндсэн хөрөнгө	273,379.69	266,818.42	-6,561.27
Номын фонд	15,189.02	-	-15,189.02
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>78,960.32</b>	<b>51,102.92</b>	<b>-27,857.40</b>
Программ хангамж	1,712.32	628.92	-1,083.40
Бусад биет бус хөрөнгө	77,248.00	50,474.00	-26,774.00
<b>Дүн</b>	<b>4,375,052.63</b>	<b>1,886,865.79</b>	<b>-2,488,186.85</b>

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### **3.4.5 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 9,581.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,500.0 мянган төгрөгөөр өссөн байна.

### **Хүснэгт 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл**

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	1,506.04	1,706.03	199.99
Бараа үйлчилгээний зардлын өглөг	279.60	7,779.60	7,500.00
Байгууллагад төлөх өглөг	95.48	95.48	0.00
<b>Дүн</b>	<b>1,881.13</b>	<b>9,581.12</b>	<b>7,500.00</b>

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 9,581.1 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн 9,581.1 мянган төгрөгийн үлдэгдлийн 7,750.6 мянган төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн, 1,706.0 мянган төгрөг нь Засаг даргын тамгын газрын, үлдэх 124.0 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн, байгаль хамгаалах сангийн өглөг эзэлж байна.

### **3.4.6 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,545,126.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,175,345.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын сан 662,806.8 мянган төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээ 508,391.7 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 1,952,828.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 2,956,976.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

## Хүснэгт 7 Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал / Засгийн газрын сан / орон нутгийн сан	1,041,195.94	378,389.05	-662,806.89
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,679,276.80</b>	<b>1,166,737.78</b>	-1,512,539.02
Өмнөх үеийн үр дүн	851,041.01	2,803,869.78	1,952,828.78
Тайлант үеийн үр дүн	1,045,140.82	(1,911,835.22)	-2,956,976.04
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	783,094.97	274,703.22	-508,391.75
<b>Дүн</b>	<b>3,720,472.74</b>	<b>1,545,126.83</b>	<b>-2,175,345.91</b>

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Баянхангай сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,074,970.5 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 175,320.4 мянган төгрөг, 2022 оны төсвийн жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 1,074,970.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 58,008.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 233,328.4 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны зардлыг 58,008.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 784.394.3 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 100,480.0 мянган төгрөгөөр, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 140,096.2 мянган төгрөгөөр, нийт 1,033,458.5 мянган төгрөгийг сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “2022 оны төсөв батлах тухай” 06 дугаар тогтоолоор баталсан байна.

Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулсан боловч жил бүр орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэмж баталж байгаатай холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 233,328.4 мянган төгрөгөөр, тодотголоор нийт урсгал үйл ажиллагааны зардлыг 99,130.8 мянган төгрөгөөр бууруулан 893,778.5 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 100,480.0 мянган төгрөгөөр, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 140,096.2 мянган төгрөгөөр, нийт 1,134,357.7 мянган төгрөгийг сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 06 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 233,328.4 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 704,553.9 мянган төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 140,096.2 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 55,000.0 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 100,480.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 875,871.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 186,930.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,030,041.6 мянган төгрөг буюу 90,8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 104,313.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

## **Хүснэгт 8 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ИТХ-ын үйл ажиллагаа	75,563.4	63,671.7	11,891.7	84%
2	ЗДТГ-ын үйл ажиллагаа	476,877.1	449,893.9	26,983.2	94%
3	ЕБС-үйлчилгээ	222,725.6	222,615.1	110.5	99,9%
4	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	59,602.3	56,937.7	2,664.6	95,5%
5	Соёл урлагийн үйлчилгээ	35,846.2	34,302.4	1,543.8	95,6%
6	ЭМТ-ийн үйлчилгээ	23,163.9	18,373.5	4,790.4	79,3%
7	Хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээ	140,096.2	92,000.0	48,096.2	65,6%
8	Хоршоо хөгжүүлэх сан	100,480.0	92,247.0	8,233.0	91,8%
	<b>Нийт</b>	<b>1,134,354.7</b>	<b>1,030,041.6</b>	<b>104,313.4</b>	<b>90,8%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв. түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 132,896.0 мянган төгрөг, ИТХ 800.0 мянган төгрөг, нийт 133,696.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого. зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

## **Хүснэгт 9 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт**

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01 2022.12.31	Сумын ИТХТ, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, хуралдааныг зохион байгуулж, мэдээлэлээр тасралтгүй хангахад оршино. Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын, мөн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж нийт 4 удаа хуралсан байна. Хэрэгжилт 93,3 %	75,563.4	63,671.7
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 4 зорилт, хэрэгжүүлэх 107 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 90,2%	476,877.1	449,893.9

3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01 2022.12.31	2022 оны 1 сараас Сүм хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх	2022 оны 01 дүгээр сараас Хоршоо хөгжүүлэх сан болж журмын дагуу шинэчлэгдсэн. Хэрэгжилт 100%	100,480.0	92,247.0
			ХХС-аас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл хөтөлбөр зээлийн сонгон шалгаруулалт зарлаж, 7 иргэн аж ахуйн нэгжид зээл олгосон. Хэрэгжилт 91,8%		
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01 2022.12.31	Ерөнхий боловсрол сургууль нь 8 зорилт 25 арга хэмжээ хэрэгжүүлэх	2022 онд “Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ” сургуулийн дундаж 67%, Хөтөлбөрийн хэрэгжилт 93,7 %	222,725.6	222,615.1
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01 2022.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 13 зорилт 49 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 88,5 %	59,602.3	56,937.7
6	71702-Соёлын үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Соёлын төв нь 6 зорилт 28 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 97,8%	35,846.2	34,302.4
7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01 2022.12.31	Нийт 8 төрлийн үзлэгт 2196 хүн, Эрүүл мэндийн даатгалын 4 багцын тусламж үйлчилгээнд 389 иргэдийг хамруулна.	Нийт 8 төрлийн эрт илрүүлэгт үзлэгт 2368 хүн, ЭМД-ын 4 багцын тусламж үйлчилгээний Өдрийн эмчилгээний багц- 38 иргэн Сэргээн засах эмчилгээний багц 81 иргэн гэрийн эргэлтийн багцад- 79 иргэн, Оношилгоо шинжилгээний багц 482 иргэн нийт 680 иргэн тус тус хамрагдсан	23,163.9	18,373.5
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 5 төслийг 140.096,2 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 1 ажил, гүйцэтгэл дуттуугаас сумас хүлээж аваагүй учир мянгийг нь дутту шилжүүлсэн 3 ажил, малын тоо толгойн албан татвараар хийж хэрэгжүүлэх 1 ажил хийгдээгүй байна. Хэрэгжилт 65,7%	140,096.2	92,000.0
Нийт дүн					1,134,354.7	1,030,041.6

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланда аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой ёгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 05/19 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны үр дүнгийн тайланийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланийн, суурь үзүүлэлтийг нийт орлого 3,428,447.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 51,426.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 38,570.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоо шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Баянхангай сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

### **4.4 Санхүүгийн тайланийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайланийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланда өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоо журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаа хоцроосон 38 мэдээлэл, мэдээлээгүй мэдээлэл байхгүй байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдо заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 05/121 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

##### **Хүснэгт 10 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	3,078.1	2	3,078.1	100%
Албан шаардлага	2	64,687.8	2	64,687.8	100%
Зөвлөмж	3	148,287.6	3	148,287.6	100%
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>212,978.4</b>	<b>7</b>	<b>212,978.4</b>	<b>100%</b>

##### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар запруулга хийгдээгүй ба 46,397.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 албан шаардлага өгсөн.

### 5.2 Албан шаардлага

Орон нутгийн орлогыг 10 нэр төрлөөр, нийт орлогын төлөвлөгөө 46,397.8 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн
ЗДТГ	1	37,682.5	1	37,682.5			1	37,682.5		
ХХСан	1	3,332.9			1	3,332.9	1	3,332.9		
Дүн	2	41,015.5	1	37,682.5	1	3,332.9	2	41,015.5		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Хариуцлага тооцуулах албан шаардлага							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Албан тушаалтны тоо	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Засаг дарга	1	46,397.8		1	46,397.8					
ЗДТГ	4	57,786.9		3	10,511.9	1	47,275.0			
ИТХ	1	642.0	1	642.0						
ХХСан	1	12,8100.0				1	12,8100.0			
Дүн	7	232,926.7	1	642.0	4	56,909.7	2	175,375.0		

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Toо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
ЗДТГ	1	0.0			1	0.0		
ЭЭС	1	42,221.7					1	42,221.7
ОНХС	1	140,096.2					1	140,096.2
Дүн	<b>3</b>	<b>182,317.9</b>			<b>1</b>	<b>0.0</b>	<b>2</b>	<b>182,317.9</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Дүн								
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>182,317.9</b>			<b>1</b>	<b>0.0</b>	<b>2</b>	<b>182,317.9</b>